

3. Монгол Улсын Хилийн төлөөлөгчийн үйл ажиллагааг өргөтгөх, тусдаа бие даасан газрын хэмжээнд зохион байгуулах

4. Тагнуул гүйцэтгэх ажлын хүч хэрэгслийг улсын хил хамгаалалтад оролцуулах гэмт үйлдлийг таслан зогсоох

5. Хил хамгаалалтын бүх төрлийн хангалтыг тухайн бүс нутгийн онцлогт тохируулан зохион байгуулах

6. Шинжлэх ухаан технологийн ололтод суурилсан шинэ техник технологийг улсын хил хамгаалалтад нэвтрүүлж, хөрш орныхоо болон олон улсын жишигт нийцүүлэх

7. Тал хээрийн бүсийн хил хамгаалах байгууллагын байгуулалтыг боловсронгуй болгож бүсчилсэн хил хамгаалалтыг зохион байгуулан, удирдлагыг оновчтой, газрын статустай хуульчилан бий болгох шаардлагатай.

Б.Мэндсайхан - Хууль сахиулахын удирдлагын академийн 821 дүгээр дамжааны суралцагч, хошууч
Я.Ариунболд - Хилийн албаны удирдлага, стратегийн, профессорын багийн профессор. хурандаа

ГЭРЭЭТ ХИЛЧНИЙ АЛБАНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АРГА ЗАМ

Хураангуй: "Гэрээт хилчин"-ий албаны онцлог албыг зохион байгуулах явцад гарч буй сөрөг үзэгдэл, тулгамдсан асуудал зэргийн шалтгаан нөхцөлийг олж, шийдвэрлэх арга замыг боловсруулах, албаны үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалтыг сайжруулах арга замыг тодорхойлохоор зорилоо.

Түлхүүр үг: Гэрээт хилчин, Удирдлага, Зохион байгуулалт.

Дэлхийн даяаршлыг дагаад зарим улс орнууд нэгдмэл холбоо үүсгэн улсын хилээр хялбарчилсан журмаар өөр хоорондоо зорчих, тэр зарчмаар бусад оронтой гэрээ хэлэлцээр хийн, асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авч. эрх зүйн орчныг бүрдүүлж байна. Хэдийгээр энэ асуудалд зорчигч, ачаа тээврийн хэрэгслийг улсын хилээр шуурхай нэвтрүүлэх гол зарчмыг баримталж байгаа боловч, нөгөө талаараа хилийн аюулгүй байдал алдагдахад хүргэж, цаашлаад олон улсын шинжтэй үндэстэн дамнасан гэмт үйлдлүүдийг даамжруулах шалтгаан болж байна.

Өнөөгийн байдлаар дэлхийн улс орнуудад терроризм, гоц халдварт өвчний тархалт, экологийн сүйрэл, байгалийн гамшигт үзэгдэл зэрэг онцгой

нөхцөл байдал үүссэн үед ажиллах болон зэвсэг, хүн, хар тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийг хууль бусаар хилээр нэвтрүүлэх, дамжин өнгөрүүлэх гэх мэт үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн гаралт өсөн нэмэгдэж байгаа энэ цаг үед Хил хамгаалах байгууллагын болон алба хаагчдын үүрэг, хариуцлага дагаад нэмэгдэх шаардлага зүйт ёсоор гарч ирж байгаа билээ.

Дээрх гэмт хэрэг, хууль бус үйлдэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, үйлдэгдсэн үед таслан зогсоох, аюулгүй байдлыг хангах талаарх хил хамгаалах байгууллагын ажиллагааг шинэ нөхцөл байдалд шинэлэг арга хэлбэрээр өөрчлөн сайжруулахыг өнөөгийн хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй нийгмийн бодит цагийн байдал нь шаардаж байна. Монгол Улсын үндэсний аюулгүй байдал болон Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах ажиллагаанд дээрх хүчин зүйлүүд сөргөөр нөлөөлж болзошгүй байгаа учраас өнөөгийн хил хамгаалалтын арга тактикийг өөрчлөх шаардлага байна.

XXI зуунд мэргэжлийн арми аюулгүй байдлын бүх асуудлыг шийдвэрлэнэ гэж гадаадын олон шинжээчид үзэж байгаа тул дэлхийн улс орнууд олон жилийн туршид зэвсэгт хүчний хуримтлуулсан ололтыг алдагдуулахгүйгээр орчин үеийн шинэ дэвшилтэт арга хэлбэр техник технологийг ашиглан цэргийн шинэчлэлийг мэргэжлийн армийн жишигт нийцүүлэн хийж олон талын үүрэг биелүүлэх чадварыг хангах бодлогыг өөр өөрийн өвөрмөц онцлогтойгоор хэрэгжүүлж байна.

Дэлхий нийтийн цэргийн хэргийн практик үйл ажиллагаанд цэргийн албыг хугацаат болон хөлсний цэргээр хамгаалдаг, үндсэндээ 2 чиглэл байдаг боловч, Монгол улсын хил хамгаалах практикт гэрээт цэргийг ашиглах ажиллагаа 1990 оны эцсээр эх суурь нь тавигдсан.

Монгол Улс ардчилсан эрх зүйт нийгмийг сонгон 1992 онд шинэ "Үндсэн хууль"-иараа баталгаажуулсан нь нийгмийн бүхий л салбарт эрс шинэчлэл хийх шаардлага гарч ирсэн бөгөөд Монгол Улсын цэргийн шинэчлэлийн бодлогын үндэс нь өөрийгөө хамгаалах, цомхон, чадварлаг, мэргэшсэн зэвсэгт хүчинтэй байх асуудал юм. Шинэчлэлийг эрчимтэй, үр дүнтэй хийх хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, шаардлагатай хөрөнгө нөөцийн асуудлыг шийдэх, бусад нөхцөл боломжийг хангах талаар Төр, Засаг, Хил хамгаалах байгууллагаас холбогдох олон төрлийн арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаагийн нэг нь гэрээт цэргийн алба юм.

Гадаадын орнуудын мэргэжлийн армиудын туршлага, Батлан хамгаалах яам болон хил хамгаалах байгууллагад гэрээт албыг зохион байгуулж буй явцаас дүгнэхэд гэрээт алба нь итгэлцлийг бэхжүүлдэг, албандаа чин сэтгэлээсээ ханддаг, сонгосон мэргэжил албаараа бахардаг.

боловсрол, эрүүл мэнд, бие бялдрын хувьд гологдох, хасагдах, халагдах магадлал багатай, нийгмийн баталгаатай, төсөв хөрөнгө хэмнэдэг, албаны сургалт бэлтгэлийн сургалт, шат дараалсан хариуцлага дээшилдэг зэрэг ач холбогдолтой байна.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, хил хязгаар, газар нутгийн бүрэн бүтэн байдалд дээрхи хүчин зүйлүүд сөргөөр нолеөлж байгаагаас өнөөгийн хил хамгаалалтын арга тактикийг өөрчилж, хил хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа хугацаат цэргийн алба хаагч, ахлагчийн бүрэлдэхүүнд шинэчлэл хийж, мэргэшсэн цэргийн алба хаагчаар хамгаалуулах шаардлага буй болсон.

Монгол Улсын "Төрөөс хилийн талаар баримтлах бодлого" -ын үндсэн чиглэлийн 1.11: “Улсын хил хамгаалах байгууллагын алба хаагчдыг мэргэшүүлэх”, Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг шинжлэх ухаан, техник, технологийн ололт, мэргэшсэн байгууллагын үйл ажиллагаанд тулгуурлан цогц байдлаар зохион байгуулах¹; Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Улсын хилийг хамгаалах үүргийг “Мэргэшсэн гэрээт хилчин”-ээр гүйцэтгүүлэх тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлэх тухай зорилт; “Бүсчилсэн хил хамгаалалт” хөтөлбөрийн “Тэрээт хилчний албыг төгөлдөржүүлж бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийн чанарыг сайжруулах” тухай зорилт зэрэг нь хил хамгаалах байгууллагад гэрээт хилчний албыг зохион байгуулах эрх зүйн үндэс болж байна.

Хил хамгаалах байгууллага нь үүрэг зориулалт, үйл ажиллагааныхаа онцлогоос хамааран гэрээт цэргийн албыг "Тэрээт хилчний алба гэсэн нэр томъёогоор зохицуулж байгаа, уг албатай холбогдсон харилцааг ХХЕГ-ын даргын 2018 оны А/117 тушаалаар батлагдсан “Хил хамгаалах байгууллагад гэрээт цэргийн албыг зохион байгуулах журам”-аар зохион байгуулж байна.

Улсын хил хамгаалах байгууллагад сайн дураар гэрээгээр цэргийн жинхэнэ алба хааж байгаа Монгол Улсын иргэнийг гэрээт хилчин гэнэ”^{1 2}.

Хил хамгаалах байгууллагад гэрээт хилчдээр улсын хил хамгаалалтыг зохион байгуулж эхэлснээс хойш эерэг болон сөрөг талууд нилээдгүй хэмжээгээр гарч байгаа тул гэрээт хилчний албанд нөлөөлж буй хүчин зүйлс тэдгээрийн эерэг болон сөрөг талуудыг судлан дүн шинжилгээ хийж, түүнээс урьдчилан сэргийлэх арга замуудыг тодорхойлж ажилласнаар хил хамгаалалтын үр дүн дээшилнэ гэж үзэж байна.

¹ Төрөөс хилийн талаар баримтлах бодлого. 1 дүгээр бүлэг. 5 зүйл.


² Монгол Улсын Хилийн тухай хууль. //өрийн мэдээлэл. 2017. №6.

Гэрээт хилчдийн гаргаж байгаа сахилгын зөрчлийг таслан зогсоох. үүрэг гүйцэтгэх чадварыг сайжруулахад удирдлагын зүгээс авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нөлөөлдөг учир анхаарах ёстой асуудлын нэг юм.

Удирдлага гэдгийг удирдлагын салбарын тэргүүний онолч Питер Ф.Друкер: "Байгууллагын зорилтуудыг томъёолж түүнд хүрэхийн тулд зайлшгүй төлөвлөх, зохион байгуулах, идэвхжүүлэх, хянах үйл явц юм". хэмээн тодорхойлсон бол судлаач Д.Давгажамц: “Зохион байгуулалтгүй бөөгнөрсөн хүмүүсийг үр ашигтай, бүтээмжтэй бүлэг болгон өөрчлөх үйл ажиллагааны онцгой хэлбэр юм”¹ үзсэн.

Дээрхээс дүгнэвэл удирдах бүрэлдэхүүний удирдах, манлайлах чадварыг нэмэгдүүлэх, ажилдаа хандах хандлага, зохион байгуулалтыг сайжруулж, хяналт шалгалтыг нэмэгдүүлснээр зөрчил дутагдал таслан зогсоогдоно гэж үзэж болохоор байна.

/Хилийн 0129 дүгээр ангид 2007-2015 оны хооронд гэрээт хилчдийн гаргасан хэрэг зөрчлийн судалгаа/



Гэрээт хилчдийн хэрэг зөрчлийн судалгаанаас үзэхэд гэрээт хилчин амралт, чөлөөний хугацааг хүндэтгэх шалтгаангүйгээр хэтрүүлэн, ажил тасалсан, мэргэжил, ур чадвар, сахилга хариуцлагын хувьд албан тушаалдаа тэнцэхгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, цэргийн дүрмийн болон сахилгын зөрчил гаргасан, эрүүл мэндийн байдал болон өөрийн хүсэлтээр, ар гэрийн гачигдлын улмаас гэрээгээ цуцалсан зэрэг нь хойшид анхаарах сөрөг бөгөөд гол асуудлууд болж байна.

Хилийн отрядод гэрээт хилчний албыг удирдан зохион байгуулахад гарч байгаа гэмт хэрэг, сахилгын зөрчлийн талаар авч үзэхэд олон талын шалтгаан нөхцөл ажиглагдаж байгаа хэдий ч эдгээр нь удирдлагын зүгээс авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай шууд холбоотой.

¹ Давгажамц Д. Менежмент. УБ., 2005.

Гэрээт хилчидтэй хилийн отряд, салбарт гарч байгаа эерэг, сөрөг талуудыг нарийвчлан гаргаж, түүнээс урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлох, энэ албыг цаашид боловсронгуй болгох ёстой гэж үзэж байна.

“Гэрээт хилчин”-ий албыг зохион байгуулснаар гарч буй үр дүн:

“Гэрээт хилчин”-ий албыг зохион байгуулж, Улсын хил хамгаалах үйл ажиллагаанд гэрээт цэргийн алба хаагчдыг үүрэг гүйцэтгүүлдэг болсноор Хилийн талаар баримтлах төрийн бодлогыг хэрэгжүүлэх, хил хамгаалах үүргийг мэргэшсэн цэргийн алба хаагчдаар гүйцэтгүүлэх үндэс тавигдаж, хариуцлагын тогтолцоо бүрдсэн.

Хил хамгаалах байгууллагад “Гэрээт хилчин”-ий албыг зохион байгуулснаар хугацаат цэргийн албан хаагчдын болон ахлагч нарын бүрэлдэхүүний албандаа хандах хандлага эрс сайжирч, урьд өмнө хил хамгаалалтад гарч байсан нийтлэг дутагдал, зөрчлүүд буурсан.

Хугацаат цэргийн албан хаагчид халагдах болон шинэ цэргүүдэд цэргийн хэргийн анхан шатны мэдлэг олгох сургалт зохион байгуулагдах үед хилийн отряд, заставууд улсын хилийг бага хүчээр хамгаалах шаардлагатай болдог “Гэрээт хилчин”-ий албанд бүрэн шилжсэн хилийн отряд, заставууд улсын хилийг бага хүчээр хамгаалах шаардлагагүй бөгөөд улсын хил хамгаалалтын нягтрал сулрах, хугацаат цэргийн албан хаагчдыг хариуцсан хэсгийнхээ газар оронг судлуулах, албанд нь дадлагажуулах сургалт явуулах зэргээр 2-3 сарын хугацаа алдах зэрэг асуудлууд байхгүй болсон юм.

Хилийн харуул удирдах, манаа ахлах, манаанд үүрэг гүйцэтгэх болон цэргийн алба хаахтай холбоотой харилцаа, сахилга, хариуцлага, бие бялдырын бэлтгэлжилт, сурлага, ёс зүйн байдал зэрэг бүхий л үйл ажиллагааг нь гэрээнд тусгаж, үр дүнг нь цалин урамшуулалтай нь шууд уялдаатайгаар тооцож, шаардлагатай үед гэрээг цуцалж болохоор уян хатан болгож өгсний үр дүнд:

- Харуулыг удирдлагагүй орхих;
- Албандаа хайнга хандах;
- Орон нутгийн иргэдийн нөлөөлөлд автах;
- Аюулгүй ажиллагааны зааврыг зөрчих;
- Хувийн янз бүрийн шалтгаанаар ахлагч нар удаан хугацаагаар албанаас хөндийрдгөөс харуул, ахлах албан тушаалтны хомсдолд ордог, нэг албан тушаалтны харуул ахлах ачаалал хэт ихэсдэг зэрэг хүндрэл арилсан.

Гэрээт хилчидтэй ажиллах арга барил нь хугацаат цэргийн алба хаагчтай ажилладагаас өөр болсон учир офицер, ахлагч нар өөртөө тавих шаардлагыг өндөрсгөж, хүнтэй ажиллах арга барил, мэдлэг боловсролоо дээшлүүлэн өөрийгөө хөгжүүлэх чин эрмэлзэлтэй болсон.

Байнгын бэлтгэлтэй гэрээт хилчдийг хилд алба хаалгаж эхэлснээр отрядын алслагдсан болон болзошгүй чиглэлд цагийн байдал үүссэн шаардлагатай үед бусад заставуудын хариуцсан хэсэгт шилжүүлэн маневрлаж, тодорхой хугацаагаар үүрэг гүйцэтгүүлэхэд гэр бүлийн байдлаас шалтгаалах хүндрэл бэрхшээл үгүй болсон.

Үүнээс гадна гэрээт албаа үлгэр жишээчээр хааж, амжилт гаргаж байгаа ихэнх гэрээт хилчид хилийн сургуульд элсэн цаашид офицер болж хил хамгаалах албанд ажиллах хүсэлтээ илэрхийлж байгаа нь чанартай офицер, боловсон хүчин бэлтгэх хөрс суурь тавигдах нөхцөл харагдаж байна

Гэрээт хилчин ”-ий албыг зохион байгуулах явцад гарч буй сөрөг үзэгдлүүд:

- Офицер, ахлагч нарын удирдах арга барил, албаны мэдлэг, хүнтэй ажиллах ур чадвар нь дутмаг

- Уг албанд иргэдийг сонгон шалгаруулж авахдаа сэтгэл зүйн тогтвортой байдлыг судалж, шалгаж авдаггүйн улмаас гэр бүлийн суурь хүмүүжил муутай, ёс суртахууны хувьд зөв төлөвшөөгүй хүнийг албанд авах магадлал өндөр

- Цэргийн жинхэнэ албыг 8 сараас доошгүй хугацаагаар хааж байгаа байлдагч, түрүүч нар хугацаат цэргийн албанаасаа шууд гэрээт цэргийн албанд шилжин орж (албаа үргэлжлүүлэн хааж), зарим нь хугацаат цэргийн албанаас зайлсхийх зорилгоор гэрээт цэргийн албанд орж байна (1 сар сургалтанд хамрагдаж, 1 сар амралт, чөлөө авч 2 сар гэрээт хилчний алба хаагаад халагдаж байна).

- Гэрээт цэргийн алба хаагчид гэрээ байгуулсан эхний 2 жилийн хугацаагаа дуусмагц ихэнх нь халагддаг бөгөөд цаашид алба хаах сонирхолтойг нь ахлагчийн албанд авч, харуулын даргын албан тушаалд томилж байгаа нь учир дутагдалтай (*насны хувьд ойролцоо, ялгарах зүйлгүй байгаа бөгөөд ажлын дадлага туршлага багатай, шаардлага сул, хүнтэй ажиллах арга барил, удирдан зохион байгуулах чадвар*) байна.

Дүгнэлт: Хилийн отряд /анги/-уудын гэрээт хилчдийн алба хаах амьдрах нөхцлийг сайжруулах ажилд ахиц дэвшил гарсан.

Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааг нийгмийн бусад салбаруудын хөгжлийн түвшинд хүргэх механизмын үндэс тавигдаж, эцсийн үр дүнгийн төлөө хүлээх хариуцлагын тогтолцоо бүрэлдэж байна.

Хил хамгаалах байгууллагад гэрээт хилчний албыг зохион байгуулж байгаа ажлын үр дүн Улаанбаатар хот болон аймаг орон нутагт хүрч гэрээт хилчний албыг сонирхож байгаа болон алба хаах залуучууд нэмэгдэж байна.

Цаашид “Гэрээт хилчин”-ий албаны үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалтыг сайжруулах санал.

- Монгол улсын хилийн тухай хуулийн 3 зүйлийн 1.3-д Улсын хил хамгаалах байгууллагад сайн дураар гэрээгээр цэргийн жинхэнэ алба хааж байгаа Монгол Улсын иргэнийг гэрээт хилчин” гэж заасан хэдий ч Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2016 оны 08 дугаар 03-ны өдрийн А/117 тушаалаар батлагдсан “Хил хамгаалах байгууллагад гэрээт цэргийн албыг зохион байгуулах журам” гэж батлагдсан нэр томъёоны хувьд зөрүүтэй байгааг журамлах.

- Харуулын дарга, жолоочийн албан тушаалд алба хаалгаж буй гэрээт цэргийн албан хаагчдад тавих мэргэжлийн шалгуур үзүүлэлтийг өндөрсгөх.

- Гэрээт хилчдийн судалгааг тухай бүр нь баяжуулан, тэдний ар гэртэй гурвалсан гэрээ байгуулан ажиллах.

- Гэрээгээр хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж албаа сайн хааж дахин гэрээ байгуулсан гэрээт хилчний цалингийн шатлалыг нэмэгдүүлэх.

- Гэрээт хилчдэд цэргийн мэргэжлийн зэрэг олгох, Энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх.

- Иргэний их дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг тус байгууллагад шаардлагатай мэргэжлээр /хүний эмч, малын эмч, холбоо, компьютер, техник, сантехник, барилгын инженер/ төгссөн дээд боловсролтой иргэдийг гэрээт хилчний албанд элсүүлж авч гэрээний хугацаа дуусахаар мэргэжлээр нь авч ажиллуулан офицер, ахлагч болгох.

- Гэрээт хилчний албаны талаар Хил хамгаалах байгууллагын судлаачид, эрдэмтэн, докторуудыг түшиглэн судалгааны ажил хийлгэж, бодит үр дүнг хэрэгжүүлэх.

- Хил хамгаалах байгууллагын ирээдүйн боловсон хүчин бэлтгэх суурь бааз болсон гэрээт хилчний албыг өргөжүүлж, төгөлдөржүүлэхийн тулд ХХЕГ-ын ЦСАЗБ- хэлтэс гэрээт хилчний албанд бүрэн шилжсэн хилийн отрядуудад гэрээт хилчин хариуцсан алба, хилийн заставт гэрээт хилчдийг хариуцсан орлогч зэрэг орон тоог бий болговол гэрээт хилчдийн албаны мэдлэг, дадлага, чадварыг дээшлүүлж, эзэнтэй болж, гэрээт хилчний алба улам боловсронгуй болгоход тодорхой түлхэц болно гэж үзэж байна.